



**ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Өндөр хяналтын өрөөний журам

Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/177 дугаар тушаал, 2022 оны А/136 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтын хэрэгжилтийг хангах, тусламж үйлчилгээний чанар сайжруулах зорилгоор “Өндөр хяналтын өрөөний журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалаар батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг тасаг нэгжийн эрхлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт даалгасугай.
3. Журмын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (Б.Бат-Оргил)-д даалгасугай,
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа)-д үүрэг болгосугай

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны ... сарын ...-ны
... дугаар тушаалын хавсралт



**ӨНДӨР ХЯНАЛТЫН ӨРӨӨ
/ХҮНД ӨВЧТӨНИЙГ ХЯНАХ ӨРӨӨ/-НИЙ ЖУРАМ**

Энэхүү журмаар өндөр эрсдэл бүхий үйлчлүүлэгчийг таньж цаг алдалгүй тохирох тусламж үйлчилгээг зориулалт бүхий тоноглогсон өрөөнд эмчилгээ үйлчилгээ явуулах үйл ажиллагааг зохицуулна.

ЗОРИЛГО

Эмнэлэгт үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс өндөр эрсдэл бүхий өвчтөнийг таньж илрүүлэн, тэдгээрт өндөр чанартай, стандарт тусламж үзүүлэх зорилготой.

АРГАЧЛАЛ

ГССҮТөвийн мэс засал болон эмийн эмчилгээний хэвтүүлэн эмчлэх тасаг бүр эрсдэлтэй өвчтөн хянах "Өндөр хяналтын өрөө"-тэй байна.

Өрөө бүр нь хүчилтөрөгчийн эх үүсгүүр болон эмчилгээ хяналтын тоног төхөөрөмжөөр тоноглогсон байна.Үүнд:

1. Хүчилтөрөгчийн найдвартай эх үүсгэвэртэй байх
2. Зүрх судасны үйл ажиллагааг хянах хяналтын төхөөрөмж /монитор/
3. Соруулах систем бүхий төхөөрөмж /отсос гм/

А. Өндөр хяналтын өрөөнд хянах шалгуур:

1. Эмнэлгийн тусламжийг тасагт үзүүлэх боломжтой бөгөөд нэмэлт хяналт шаардлагатай
2. Хамгийн багадаа 4 цагаар амин үзүүлэлтийг үзэж хянах шаардлагатай
 - Амьсгалын тоо хэвийн үзүүлэлтээс ихэссэн буюу багассан
 - Зүрхний цохилт хэвийн үзүүлэлтээс ихэссэн буюу багассан
 - Артерийн даралт хэвийн үзүүлэлтээс ихэссэн буюу багассан
 - Үргэлжилсэн бөөлжилт, огиулалт
3. Өвчтөний биеийн байдал цаашид хүндэрч болох эрсдэлтэй.
4. Ойрын хугацаанд эрчимт эмчилгээнд эмчлэгдэж байсан
5. Цаашид эмчилгээ, тусламж үйлчилгээнд эрчимт эмчилгээний багийн дэмжлэг зөвлөгөө хэрэгцээтэй байгаа
6. Удаан үргэлжилсэн мэс заслын дараах өндөр хяналт шаардлагатай өвчтөн
7. Тасагт хийгдсэн төрөл бүрийн ажилбарын дараах өндөр хяналт шаардлагатай өвчтөн

Б. Өндөр хяналтын өрөөнөөс гаргах шалгуур:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасгийн энгийн өрөөнд үзүүлэх боломжтой нэмэлт хяналт шаардлагагүй
2. Амин үзүүлэлтийг 12 цагаар үзэж хянах боломжтой
3. Амин үзүүлэлтүүд нь хэвийн үнэлгээтэй
4. Хүчилтөрөгчийн /O2/ дэмжлэг авах шаардлагагүй

Яаралтай тусламжийн тэргэнцэрийг өндөр хяналтын өрөөнд эсхүл ойролцоо байлгана.

95

В. Өндөр хяналтын өрөөнд өвчтөн хянахад эмнэлгийн мэргэжилтнүүдийн оролцоо:

1. Тасгийн эрхлэгчийн:
 - Өндөр хяналт бүхий үйлчлүүлэгчийн эмчилгээ үйлчилгээнд өдөр бүр хяналт хийж зөвлөн тусална.
 - Шаардлагатай бол үйлчлүүлэгчийг шилжүүлэх шийдвэрийг гаргана.
2. Эмчлэгч эмчийн:
 - Үйлчлүүлэгчийн биеийн байдалд өдөрт 2-3 удаа үнэлгээ өгөн өвчний цахим түүхэнд тэмдэглэл хөтөлнө.
 - Өдөр бүрийн эмчилгээнд хяналт хийнэ.
 - Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлэлт өгөн шилжүүлэх саналыг тасгийн эрхлэгчид мэдэгдэн хамтран шийдвэрлэнэ.
3. Ахлах сувилагчийн:
 - Үйлчлүүлэгчийн эмчилгээ үйлчилгээнд өдөр бүр хяналт хийнэ.
 - Яаралтай тусламжийн тэргэнцрийн бэлэн байдлыг хангана.
4. Сувилагчийн:
 - Өдөр тутмын эмчилгээг эмчийн заасан заалтаар цаг тухайд нь хийнэ
 - Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийн өөрчлөлтийг эмчлэгч эмчид цаг тухайд нь мэдээлнэ.
 - Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг цахим түүхэнд цаг тухайд нь тэмдэглэнэ.
5. Жижүүр эмчийн үүрэг:
 - Өндөр хяналтын өрөөнд буй өвчтөн үйлчлүүлэгчийн эмчилгээ үйлчилгээнд жижүүрийн хугацаанд хяналт тавина.
 - Үзүүлсэн тусламж үйлчилгээний талаар цахим түүхэнд тэмдэглэн жижүүрийн мэдээнд танилцуулна.